



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/001/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2026.02.25	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: М.Алтантуяа Утас: 99061829 Цахим хаяг: Altantuyam@audit.gov.mn Аудитор: А.Адилзаяа Утас: 80870886 Цахим хаяг: Adilzayaa@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудит хийгдээгүй болно.	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
МУГБХНХС	Монгол улсын гэр бүл хүүхэд, нийгмийн хамгааллын сайд
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар





БАЯНХОНГОР АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА Э.ЭНХТӨР ТАНАА

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2026.02.12 № 2/06
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлын онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/12 дугаар захирамжаар “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв”-ийг тус байгууллагын харьяалалд шилжүүлснээр урсгал зардлыг 2026 оноос улсын төсвөөс санхүүжүүлэхээр болсон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн

6426650020

/2026 он/1. бичиг хэрэг/тоот/2. а4-
албан тоот.docx

асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 27 зорилтын хүрээнд нийт 90 ажил төлөвлөснөөс хэрэгжилтийн хувь 98.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>34,943,414.00</u>	<u>30,513,775.89</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	15,480,000.00	00.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	15,480,000.00	00.00
3121	Төгрөг	15,480,000.00	00.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	15,480,000.00	00.00
33	АВЛАГА	00.00	6,670,651.89
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	135,251.89
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	6,535,400.00
35	БАРАА МАТЕРИАЛ	19,463,414.00	23,843,124.00
354	Хангамжийн материал	19,463,414.00	23,843,124.00
35410	Бичиг хэргийн материал	2,479,790.00	742,500.00
35420	Аж ахуйн материал	16,983,624.00	23,100,624.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,440,488,170.16</u>	<u>2,482,013,022.76</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,440,488,170.16	2,482,013,022.76
392	Биет хөрөнгө	2,384,963,170.16	2,426,488,022.76
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,498,898,626.00	2,498,898,626.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-267,497,841.55	-317,368,774.39
39203	Авто-тээврийн хэрэгсэл	49,998,000.00	24,999,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-49,998,000.00	-4,166,500.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	224,917,007.24	274,408,107.24
39206	Хуримтлагдсан элэгдэл	-95,471,453.04	-113,062,401.22
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	159,502,137.40	160,185,293.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-135,385,305.89	-97,405,327.87
393	Биет бус хөрөнгө	55,525,000.00	55,525,000.00
39301	Програм хангамж	8,105,000.00	8,105,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-8,105,000.00	-8,105,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	55,525,000.00	55,525,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН Ш=I+II	<u>2,475,431,584.16</u>	<u>2,512,526,798.65</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>15,402,491.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	15,402,491.00
413	Өглөг	00.00	15,402,491.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	1,011,276.00
4136	Бусад өглөг	00.00	14,391,215.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	1,956,215.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	12,435,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,475,431,584.16</u>	<u>2,497,124,307.65</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,475,431,584.16	2,497,124,307.65
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,454,481,459.57	1,454,481,459.57
51101	Өмч: - төрийн	1,454,481,459.57	1,454,481,459.57

512	Хуримтлагдсан үр дүн	976,969,560.02	998,662,283.51
51210	Өмнөх үеийн үр дүн	976,969,560.02	976,969,560.02
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	21,692,723.49
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	43,980,564.57	43,980,564.57
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,475,431,584.16	2,512,526,798.65

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,477,875,891.20	2,647,275,958.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,051,238,733.00	133,785,986.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,051,238,733.00	133,785,986.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,480,000.00	3,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,480,000.00	3,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,426,637,158.20	2,513,489,972.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,160,839,900.00	2,290,488,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,160,839,900.00	2,290,488,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	265,797,258.20	223,001,772.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	197,402,786.20	204,421,452.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	67,904,472.00	12,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	490,000.00	6,580,320.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,483,277,163.61	2,625,583,235.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,483,277,163.61	2,625,583,235.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,249,202,242.99	2,459,611,565.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,648,386,810.50	1,819,350,488.20
210101	Үндсэн цалин	810,123,695.87	837,859,968.88
210102	Нэмэгдэл	496,722,575.37	583,010,347.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	224,642,860.73	326,405,971.91
210104	Урамшуулал	116,897,678.53	72,074,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	205,762,647.00	227,088,321.63
210201	Тэтгэврийн даатгал	141,745,047.00	163,367,137.63
210202	Тэтгэмжийн даатгал	16,004,300.00	16,205,796.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,002,200.00	8,220,998.00
210204	Ажилгүйдлийн даатгал	8,002,300.00	7,824,498.00
210205	Эрүүл мэндийн даатгал	32,008,800.00	31,469,892.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	87,377,535.14	155,167,141.52
210301	Гэрэл, цахилгаан	5,882,856.64	13,443,157.05
210302	Түлш, халаалт	73,400,888.50	132,477,664.00
210303	Цэвэр, бохир ус	8,093,790.00	9,246,320.47

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	12,998,712.94	12,031,254.00
210401	Бичиг хэрэг	5,018,000.00	5,708,090.00
210402	Тээвэр, шатахуун	4,485,925.00	2,429,195.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,273,197.94	1,573,569.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,221,590.00	2,320,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,835,000.00	7,496,192.00
210604	Урсгал засвар	2,835,000.00	7,496,192.00
2107	Томилолт, зочны зардал	5,943,000.00	4,300,000.00
210702	Дотоод албан томилолт	5,943,000.00	4,300,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	209,747,932.00	118,400,035.17
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	208,218,572.00	116,117,575.17
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	738,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	198,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	77,500.00	85,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	901,200.00	848,000.00
210807	Газрын төлбөр	317,660.00	380,460.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	76,150,605.41	115,778,133.40
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	76,150,605.41	115,778,133.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	234,074,920.62	165,971,669.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	234,012,739.00	95,924,256.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	12,435,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,324,839.00	75,900,756.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	210,927,900.00	7,588,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,760,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	62,181.62	70,047,413.09
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	62,181.62	70,047,413.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	994,598,727.59	21,692,723.49
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	994,598,727.59	21,692,723.49

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,442,117,158.20	2,516,489,972.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,480,000.00	3,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	15,480,000.00	3,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,480,000.00	3,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,480,000.00	3,000,000.00

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,426,637,158.20	2,513,489,972.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,160,839,900.00	2,290,488,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,160,839,900.00	2,290,488,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	265,797,258.20	223,001,772.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	197,402,786.20	204,421,452.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	67,904,472.00	12,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	490,000.00	6,580,320.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,412,048,758.20	2,505,452,972.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,412,048,758.20	2,505,452,972.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,177,973,837.58	2,345,380,903.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,648,386,810.50	1,819,350,488.20
210101	Үндсэн цалин	810,123,695.87	837,859,968.88
210102	Нэмэгдэл	496,722,575.37	583,010,347.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	224,642,860.73	326,405,971.91
210104	Урамшуулал	116,897,678.53	72,074,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	205,762,647.00	227,223,573.52
210201	Тэтгэврийн даатгал	141,745,047.00	163,502,389.52
210202	Тэтгэмжийн даатгал	16,004,300.00	16,205,796.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,002,200.00	8,220,998.00
210204	Ажилгүйдлийн даатгал	8,002,300.00	7,824,498.00
210205	Эрүүл мэндийн даатгал	32,008,800.00	31,469,892.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	87,377,535.14	155,095,435.05
210301	Гэрэл, цахилгаан	5,882,856.64	13,443,157.05
210302	Түлш, халаалт	73,400,888.50	131,466,388.00
210303	Цэвэр, бохир ус	8,093,790.00	10,185,890.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,052,712.94	8,559,649.00
210401	Бичиг хэрэг	6,072,000.00	3,736,800.00
210402	Тээвэр, шатахуун	4,485,925.00	1,213,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,273,197.94	1,212,749.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,221,590.00	2,396,400.00
2105	Нормативт зардал	908,500.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	908,500.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,665,000.00	7,996,192.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,650,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	3,015,000.00	7,496,192.00
2107	Томилолт, зочны зардал	5,943,000.00	4,300,000.00
210702	Дотоод албан томилолт	5,943,000.00	4,300,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	210,877,632.00	122,855,565.64
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	209,455,472.00	120,600,005.64

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	738,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	198,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	77,500.00	85,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	794,000.00	821,100.00
210807	Газрын төлбөр	317,660.00	380,460.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	234,074,920.62	160,072,069.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	234,012,739.00	83,489,256.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,324,839.00	75,900,756.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	210,927,900.00	7,588,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,760,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	62,181.62	70,047,413.09
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	62,181.62	70,047,413.09
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	6,535,400.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	6,535,400.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	30,068,400.00	11,037,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	14,588,400.00	26,517,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,588,400.00	26,517,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	14,588,400.00	26,517,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,588,400.00	26,517,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-14,588,400.00	-26,517,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	15,480,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15,480,000.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Төгрөгөөр/
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,454,481,459.57	43,980,564.57	-17,629,167.57	1,480,832,856.57
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,454,481,459.57	43,980,564.57	-17,629,167.57	1,480,832,856.57
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	994,598,727.59	994,598,727.59
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,454,481,459.57	43,980,564.57	976,969,560.02	2,475,431,584.16
D01	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,454,481,459.57	43,980,564.57	976,969,560.02	2,475,431,584.16

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,454,481,459.57	43,980,564.57	976,969,560.02	2,475,431,584.16
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	21,692,723.49	21,692,723.49
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,454,481,459.57	43,980,564.57	998,662,283.51	2,497,124,307.65

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

ЭЗА	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,304,061,900.00	2,220,440,786.91	83,621,113.09	96.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,304,061,900.00	2,220,440,786.91	83,621,113.09	96.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,217,335,200.00	2,136,951,530.91	80,383,669.09	96.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,829,125,100.00	1,765,473,728.70	63,651,371.30	96.5
210101	Үндсэн цалин	826,118,100.00	815,792,966.88	10,325,133.12	98.8
210102	Нэмэгдэл	647,634,900.00	552,388,589.91	95,246,310.09	85.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	223,900,000.00	325,217,971.91	-101,317,971.91	145.3
210104	Урамшуулал	131,472,100.00	72,074,200.00	59,397,900.00	54.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	228,554,400.00	222,822,593.21	5,731,806.79	97.5
210201	Тэтгэврийн даатгал	155,508,400.00	159,570,393.21	-4,061,993.21	102.6
210202	Тэтгэмжийн даатгал	18,286,400.00	16,088,500.00	2,197,900.00	88.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,153,700.00	8,162,400.00	991,300.00	89.2
210204	Ажилгүйдлийн даатгал	9,118,200.00	7,765,900.00	1,352,300.00	85.2
210205	Эрүүл мэндийн даатгал	36,487,700.00	31,235,400.00	5,252,300.00	85.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	132,694,000.00	132,694,000.00	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	16,459,400.00	13,443,157.05	3,016,242.95	81.7
210302	Түлш, халаалт	108,955,000.00	109,064,952.95	-109,952.95	100.1
210303	Цэвэр, бохир ус	7,279,600.00	10,185,890.00	-2,906,290.00	139.9
2104	Хангамж, бараа материалын зардал	7,951,400.00	6,805,649.00	1,145,751.00	85.6
210401	Бичиг хэрэг	3,038,800.00	3,736,800.00	-698,000.00	123.0
210402	Тээвэр, шатахуун	1,434,500.00	1,213,700.00	220,800.00	84.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,014,600.00	1,212,749.00	801,851.00	60.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	537,700.00	00.00	537,700.00	0.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	925,800.00	642,400.00	283,400.00	69.4
2105	Нормативт зардал	1,648,100.00	00.00	1,648,100.00	0.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,648,100.00	00.00	1,648,100.00	0.0

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,342,000.00	2,600,000.00	1,742,000.00	59.9
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,242,000.00	500,000.00	1,742,000.00	22.3
210604	Урсгал засвар	2,100,000.00	2,100,000.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	10,296,000.00	4,300,000.00	5,996,000.00	41.8
210702	Дотоод албан томилолт	10,296,000.00	4,300,000.00	5,996,000.00	41.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,724,200.00	2,255,560.00	468,640.00	82.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	99,800.00	00.00	99,800.00	0.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	738,000.00	738,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	198,000.00	198,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	85,000.00	85,000.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,069,100.00	821,100.00	248,000.00	76.8
210807	Газрын төлбөр	501,300.00	380,460.00	120,840.00	75.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	86726700.00	83489256.00	3,237,444.00	96.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	86,726,700.00	83,489,256.00	3,237,444.00	96.3
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	76,593,600.00	75,900,756.00	692,844.00	99.1
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	10,133,100.00	7,588,500.00	2,544,600.00	74.9
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,386,627,400.00	2,290,488,200.00	96,139,200.00	96.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,386,627,400.00	2,290,488,200.00	96,139,200.00	96.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,386,627,400.00	2,290,488,200.00	96,139,200.00	96.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	55	54	1	98.2
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	46	45	1	97.8
620003	Үйлчлэх ажилтан	8	8	0	100.0

2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	223,001,772.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	223,001,772.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	223,001,772.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	53,876,759.50
210101	Үндсэн цалин	22,067,002.00
210102	Нэмэгдэл	30,621,757.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,188,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,400,980.31
210201	Тэтгэврийн даатгал	3,931,996.31
210202	Тэтгэмжийн даатгал	117,296.00

210203	ҮОМШӨ-ний даатгал	58,598.00
210204	Ажилгүйдлийн даатгал	58,598.00
210205	Эрүүл мэндийн даатгал	234,492.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,401,435.05
210302	Түлш, халаалт	22,401,435.05
2104	Хангамж, бараа материалын зардал	1,754,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,754,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,396,192.00
210604	Урсгал засвар	5,396,192.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	135,172,405.64
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	135,172,405.64
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	223001772.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	223,001,772.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	204,421,452.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,580,320.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар хүн амын хөгжил, хөдөлмөр, нийгмийн хамгааллын харилцан уялдаатай цогц бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлж, иргэдийн хөдөлмөрлөх, хөгжих таатай орчин бий болгох, нийгмийн баталгааг дээшлүүлэх замаар хүний хөгжлийг хангах зорилгынхоо хүрээнд 2025 онд төрийн үйлчилгээг нээлттэй, түргэн шуурхай, ил тод болгох замаар төр, иргэн, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх, төрийн үйлчилгээнд цахим технологийг нэвтрүүлж, мэдээллийн технологиор тэргүүлэх байгууллага болох зорилт дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын дотоод аудит/аудиторын чиг үүргийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Хяналт, үнэлгээ дотоод аудитын газар хэрэгжүүлдэг ба тайлант онд хяналт шалгалт хийгдсэн талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, “Төсвийн тухай хууль” болон бусад холбогдох хууль, журмуудыг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны санхүүгийн тайланг “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 37,095.21 мянган төгрөг буюу 1.04 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөгөөр/		
Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	34,943.41	30,513.78	-4,429.64
МӨНГӨН ХӨРӨНГӨ	15,480.00	00.00	-15,480.00
АВЛАГА	00.00	6,670.65	6,670.65
БАРАА МАТЕРИАЛ	19,463.41	23,843.12	4,379.71
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,440,488.17	2,482,013.02	41,524.85
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,440,488.17	2,482,013.02	41,524.85
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,475,431.58	2,512,526.80	37,095.21
НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	15,402.49	15,402.49
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,475,431.58	2,497,124.31	21,692.72
Засгийн газрын хувь оролцоо	2,475,431.58	2,497,124.31	21,692.72
Хуримтлагдсан үр дүн	976,969.56	998,662.28	21,692.72
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,475,431.58	2,512,526.80	37,095.21

Тус байгууллага мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдлийг улсын болон орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна.

Авлагын дансны үлдэгдэл 6,670.7 мянган төгрөг болж өссөн нь татаас санхүүжилтийн авлага (ахмадын сангийн дансны үлдэгдэл) 6,535.4 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 135.3 мянган төгрөгийн үлдэгдэл нөлөөлжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 23,843.2 мянган төгрөг болж оны эхний үлдэгдлээс 4,379.71 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд нийт орлогод авсан бараа материалаас аж ахуйн материалын 6,117.0 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэл голлох нөлөөг үзүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,482,013.02 мянган төгрөг болж оны эхний үлдэгдэл хөрөнгөөс 41,524.8 мянган төгрөгөөр өссөн шалтгаан нь тайлант онд ХХҮЕГ-ын 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 2/213 дугаар тушаал, МУГБХНХСайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/131 дүгээр тушаал, ХХҮЕГ-ын даргын 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн А/303 дугаар тушаалыг тус тус үндэслэн 70,666.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй, байгууллагын даргын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/09 дүгээр тушаалаар 11,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан нь голлох нөлөөг үзүүлжээ. Мөн тус байгууллага нь 47,009.2 мянган төгрөгийн 122 нэр төрлийн тавилга, эд хогшил, тоног төхөөрөмжийг ТӨБЗГ-ын 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 356 дугаар тогтоолоор актлаж устган, ТӨБЗГ-ын 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 296 дугаар тогтоолоор байгууллагад үндсэн хөрөнгөөр бүртгэлтэй автомашиныг дахин үнэлүүлж 24,999.0 мянган төгрөгөөр бууруулан үндсэн хөрөнгийг дансыг хорогдуулсан байна.

Байгууллагын биет бус хөрөнгөд бүртгэлтэй 8,105.0 мянган төгрөгийн өртөг бүхий Санхүүгийн тооцоолох группийн "Acolous" программыг урсгал зардлын төсвөөс 473.0 мянган төгрөгөөр ашиглах эрх худалдан авч, өдөр тутмын санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тайлант онд өглөгийн дансны үлдэгдэл 15,402.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны 12 дугаар сард санхүүжилт дутуу олгогдсноос 1,011.3 мянган төгрөгийн түлш халаалтын өглөг, 1,956.2 мянган төгрөгийн байгууллагад төлөх өглөг, Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйл 82.1-т заасны дагуу орон тооны цомхотголд орсон 4 албан хаагчид ажилгүйдлийн тэтгэмжид 12,435.0 мянган төгрөгийн өглөг үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,497,124.3 мянган төгрөг болж 21,692.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн хуримтлагдсан үр дүн 21,692.7 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,009,073.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3,009,073.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 547 дугаар албан бичгээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь ХХҮЕГ-ын даргын 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/15 дугаар тушаалыг үндэслэн газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар байгууллагын бүтцийг 55 орон тоотойгоор баталж, үйл ажиллагаа явуулсан бөгөөд ХХҮЕГ-ын даргын 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А/37 дугаар “Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” тушаалаар орон тоог 9 хувиар бууруулан 50 орон тоотой үйл ажиллагаа явуулахаар баталсан байна.

Тайлант онд байгууллагын хоол, унааны хөнгөлөлтөд улсын төсвөөс 223,900.0 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 325,217.8 мянган төгрөг зарцуулсан байна. Тус хөнгөлөлтийг байгууллагын хамтын гэрээний 5.1.12 дахь заалт, дотоод журмын 10.3.13 дахь заалтыг үндэслэн байгууллагын даргын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн Б/16 дугаар тушаалаар аймгийн төвийн албан хаагчдад өдрийн 34.0 мянган төгрөг, сум хариуцсан албан хаагчдад өдрийн 20.0 мянган төгрөгөөр тогтоожээ.

2025 онд улсын төсвийн санхүүжилтээр 2,386,627.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,290,488.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, үүнээс урсгал үйл ажиллагаанд 2,220,440.8 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст дансны үлдэгдэл 70,047.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,220,440.8 мянган төгрөг буюу нийт батлагдсан төсвийн 96.4 хувийг зарцуулсан байгаа нь нийт санхүүжилт улсын төсвөөс 96,139.2 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71902 Нийгмийн халамж					
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,911,958.80	1,901,029.50	10,929.30	99.43
2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	86,726.70	84,182.10	2,544.60	97.07
3	81569 Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	99.80	-	99.80	-
4	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	305,276.60	305,276.60	-	100.00

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.2 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд ХХҮЕГ-ын халамжийн сангаас тус байгууллагын нийгмийн халамжийн хэлтсийн өрхийн амьжиргааны судалгааны зардалд 12,000 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 204,421.5 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 6,580.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, бүрэн зарцуулсан байна.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйл 10.2-т заасны дагуу 19,377.8 мянган төгрөгийн 8 гэрээг шууд худалдан авалтын аргаар зохион байгуулж, бараа, ажил, үйлчилгээ авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Адилзаяа гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 602 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.



4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсөв болох 2,304,061.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 23,042.1 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 14,977.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт мэдээлбэл зохих цалингийн зардлаас бусад 5 саяас дээш дүнтэй орлогын 74,254.0 мянган төгрөгийн 7 гүйлгээ, зарлагын 22,792.0 мянган төгрөгийн 3 гүйлгээ болон байгууллагын үндсэн мэдээлэл хэсэгт нягтлан бодогчийн мэдээллийг ил тод байршуулаагүй тул аудитын явцад нөхөн мэдээлж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

2024 оны санхүүгийн тайлангийн аудитыг Төрийн аудитын байгууллагын аудитор Д.Эрдэнэбулган гүйцэтгэсэн бөгөөд аудитаар алдаа зөрчил илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт хүргүүлсэн байна.



4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 198,563.8 мянган төгрөгийн 4 зөрчил¹ илэрснээс 101,317.8 мянган төгрөгийн 1 зөвлөмж, 97,046.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 200.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоов.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 198.363.8 мянган төгрөгийн материаллаг бусаар тооцсон ба залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 2025 оны 05 дугаар сарын ажилчдын цалинг олгохдоо Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн ажилтанд олгосон цалингийн урьдчилгаа болох 200.0 мянган төгрөгийг суутган тооцоогүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь “Хариуцлагатай байх”, 16 дугаар зүйл 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4 дэх “Үнэн зөв байх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцон олгосон цалингийн урьдчилгаа 200.0 мянган төгрөгийг албан хаагчаар буцаан төлүүлж, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1 Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 618м.кв талбай бүхий газрын мэдээллийг Төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ, (egazar.gov.mn)-тэй тулган шалгахад 882.0 м.кв газар дутуу буюу зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт “Үнэн зөв байх”, 13 дугаар зүйл, 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, УСОУНББ 17 – Үндсэн хөрөнгө 17.12-т Үндсэн хөрөнгийн бүртгэлд эзэмшиж буй газар, барилга, байгууламжийн хэмжээ, үнэлгээг үнэн зөв тусгана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын нэр дээр бүртгэлтэй газрын хэмжээг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай тулган баталгаажуулж нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусган зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.



5.2.2 Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын шилэн дансны нэгдсэн цахим системд байгууллагын үндсэн мэдээлэл хэсэгт нягтлан бодогчийн мэдээлэл оруулаагүй, цалингийн зардлаас бусад 74,254.0 мянган төгрөгийн орлогын 7 гүйлгээ, 22,792.1 мянган төгрөгийн зарлагын 3 гүйлгээ, Хөдөлмөр эрхлэлэлтийг дэмжих сангийн шилэн дансны цахим системд орлогын 792,835.6 мянган төгрөгийн орлогын 13 гүйлгээ, зарлагын 240,817.0 мянган төгрөгийн 24 гүйлгээг мэдээлээгүй орхигдуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд нөхөж мэдээлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

5.3.1 Тус байгууллага нь ҮЭ-ийн хороотойгоо хамтын гэрээ байгуулж хоолны хөнгөлөлтийн нэг өдрийн хэмжээг өсгөсөн боловч тайлант онд батлагдсан 223,900.0 мянган төгрөгийн төсөвт өөрчлөлт оруулаагүйгээс төсвийг 101,317.8 мянган төгрөгөөр хэтрүүлэх нөхцөл үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.2.3 дахь “Урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 16.5.3. дахь “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 42 дугаар зүйл 42.2.2 дахь “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл 15.2.6 дахь “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан хаагчдад олгох хоол, унааны хөнгөлөлтийн нэг өдөрт ногдох нөхөх төлбөрийг Хамтын гэрээ, дотоод журмаар нэмэгдүүлэн өөрчлөлт оруулсан бол түүнийг үндэслэн төсвийг нэмэгдүүлэн төлөвлөж батлагдсан төсвийн хүрээнд хоол, унааны хөнгөлөлтийг олгож байх зөвлөмж хүргүүлэв.



6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим системд байгууллагын үндсэн мэдээлэл хэсэгт нягтлан бодогчийн мэдээлэл оруулаагүй, цалингийн зардлаас бусад 867,089.6 мянган төгрөгийн орлогын 20 гүйлгээ, 263,609.1 мянган төгрөгийн зарлагын 27 гүйлгээг мэдээлээгүй орхигдуулсан байна.	1	97,046.0			1	97,046.0		
2025 оны 05 дугаар сарын ажилчдын цалинг олгохдоо Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн ажилтанд олгосон цалингийн урьдчилгаа болох 200,000 төгрөгийг суутган тооцоогүй байна.	1	200.0	1	200.0				
Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 618м.кв талбай бүхий газрын мэдээллийг Төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ, (egazar.gov.mn)-тэй тулган шалгахад 882.0 м.кв газар дутуу зөрүүтэй байна	1	-			1	-		
Тус байгууллага нь ҮЭ-ийн хороотойгоо хамтын гэрээ байгуулж хоолны хөнгөлөлтийн нэг өдрийн хэмжээг өсгөсөн боловч тайлант онд батлагдсан 223,900.0 мянган төгрөгийн төсөвт өөрчлөлт оруулаагүйгээс төсвийг 101,317.8 мянган төгрөгөөр хэтрүүлэх нөхцөл үүссэн байна.	1	101,317.8					1	101,317.8
Дүн	4	198,563.8	1	200.0	2	97,046.0	1	101,317.8

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

